

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны ..... дугаар сарын .....-ний  
өдрийн  
хуралдааны ..... дугаар тогтоолын хавсралт

## БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь тус сумын бэлчээрийг нөөц, даацад нь тохируулан зохистой ашиглаж, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, бэлчээр ашиглалтыг экологийн чадавхад суурилсан аргачлалаар төлөвлөх, уг төлөвлөгөөний дагуу улирлын хуваарьтайгаар, зүй зохистой ашиглаж, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Газрын тухай хуулийн 50.1.1-т заасны дагуу бэлчээрийн төлөв байдал чанарыг хадаглах, хөрсний үржил шим буурах, бэлчээрийн ургамлын бүрхэвч талхлагдаж хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих бохирдохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг бэлчээр ашиглагч малчин хариуцна.
- 1.3 Сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Үндсэн хууль, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангахад бэлчээр, ус ашиглагч малчид, бүлэг, аж ахуйн нэгж, байгууллагууд энэхүү журмыг мөрдлөгө болгон ашиглана.

### ХОЁР. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарийг хэрэгжүүлэх.

- 2.1. Бэлчээр ашиглалтыг тухайн аймаг, сум, багийн бэлчээрийн экологийн чадавх, бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт болон мониторингийн тухайн жилийн дүн мэдээлэлд үндэслэн улирлаар, тодорхой хугацаагаар төлөвлөх зарчмаар зохицуулна.
- 2.2. Зуслан-намаржааны бэлчээрийг СГЗБТЖТ-ний дагуу өрх, хот айл, бүлэг, хэсгээр зүй зохистой ашиглах
- 2.3. Бэлчээр ашиглагчдад гэрээгээр ашиглуулж байгаа болон уламжлалт зохицуулалтаар ашиглаж байгаа бэлчээрээр мал дайран өнгөрөх, тууварлах, түр буудаллах хугацааг 2-7 хоногоос илүүгүйгээр тогтооно.
- 2.4. Өвөлжөө, хаваржааны бэлчээрээс бүх өрх (5 дугаар сарын 15) ны дотор зусланд гарч, малаас бүрэн чөлөөлнө. *дугаар сарын өөрчлөх.*
- 2.5. Улирлаар ашиглах бэлчээрээс нүүх, буух хугацааг газарзүйн онцлог ба цаг агаарын нөхцөлөөс хамааруулан өөрчлөж болох бөгөөд энэ өөрчлөлт нь зөвхөн тухайн улирал, жилд мөрдөгдөнө.
- 2.6. Газар тариалангийн бүс орчмын бэлчээрийг зөвхөн тухайн оны 10 дугаар сарын 01-ээс дараа оны 5 дугаар сарын 1 хүртлэх хугацаанд ашиглана. →

2.7.Зуслан-намаржааны бэлчээрийг тариалангийн талбайн захаас 500 метрээс доошгүй зайд байрлахаар зохион байгуулалт хийж, бэлчээр ашиглалтыг зохицуулна.

2.8.Шилжин ирэхээр хүсэлтээ гаргасан мал бүхий малчин өрхийг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, шилжиж ирхийг зөвшөөрсөн тохиолдолд багийн иргэдийн Нийтийн Хурлаас өвөлжөө, хаваржааны нутгийг зааж өгөх ба жилийн дөрвөн улиралд нутаглаж аймаг, сум, багаас баталсан журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

2.9. Сум болон сум дундын отрын нөөц бэлчээрт орох, гарах буюу дамжин өнгөрөх маршрутыг сумын Засаг даргын захирамжаар тогтооно.

2.10.Отрын нөөц бэлчээрт орох малд сумын Мал эмнэлгийн тасаг малын эрүүл мэндийн тодорхойлолт гаргах, мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.

2.11.Тусгай хамгаалалттай болон хилийн бүс, хилийн зурвас газрын бэлчээрийг ашиглахдаа холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

2.12.Тухайн бэлчээрт байгаа байгалийн баялаг, ан амьтдыг хамгаалах, амьдрах орчин нөхцөлийг хангаж ашиглана.

2.13. Бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд орон нутгийн зам болон малын хөлөөс чөлөөлсөн бэлчээрийг тэмдэгжүүлэх, шинэ зам гаргахгүй байх, чөлөөлсөн бэлчээрт мал оруулахгүй байх анхааруулга тавих ажлыг аймаг, сум, багийн Засаг дарга нар хариуцан хэрэгжүүлнэ.

2.14. Шинээр өрх тусгаарласан малчин өрхөд өвөлжөө, хаваржаа барих асуудлыг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, гаргасан саналыг үндэслэн сумын Засаг дарга, газрын даамалд мэдэгдэж өвөлжөө, хаваржааны газрыг шийдвэрлүүлнэ.

2.15. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын зардлыг аймаг, сумын төсөв, Малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлнэ.

2.17. Өвөлжөө хаваржааны бэлчээр нутагт өвөлжөө хаваржаа шинээр гаргах, малын хашаа саравч барихад БИНХ-аар оруулан шийдвэрлэж, сум, багийн Засаг дарга, газрын даамалд мэдэгдэж бүртгүүлэх

2.18.Өвөлжөө хаваржааны хашаа, саравчийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй, газрын гэрээ гэрчилгээ гараагүй нөхцөлд бусдад шилжүүлэх, зархийг хориглоно. Газар эзэмших гэрчилгээтэй өвөлжөө, хаваржааг газрын хамт өөр өрхөд худалдаалах бол хөрш өрхтэй зөвшилцөж багийн Засаг даргад мэдэгдэх. ~~2.18.~~ Өөр аймаг, сумаас отроор ирсэн малчидтай "Бэлчээр ашиглах гэрээ" байгуулна.

2.19. Уламжлалт өв соёлыг сурталчлах, нийтийг хамарсан спортын болон бусад арга хэмжээний үед малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээр ашиглалтын хуваарийг малын төрөл тус бүрээр нарийвчлан тогтоох асуудлыг нутгийн онцлогт нийцүүлэн тогтоож ажиллана. ✓

### ГУРАВ. Бэлчээр ашиглагчдын эрх, үүрэг.

3.1.Бэлчээр ашиглагч малчин, бүлэг дараах үүрэг хүлээнэ.

3.2.Бэлчээрийн даацад тохирсон тооны малыг өсгөн үржүүлэх, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх.

3.3.Сүргийн эргэлтийн төлөвлөлттэй уялдуулан, бэлчээрийн даац багтаамжаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулдаг байх.

3.4.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажилд оролцож, бэлчээрийг өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх, гарсан шийдвэрийг дагаж мөрдөх.

3.4.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарьт тусгагдсанаас бусад бэлчээрт дур мэдэн нутаглахгүй байх, зөвшөөрөлгүйгээр өвөлжөө, хаваржааг шинээр барихгүй байх.

3.5.Бэлчээр, байгаль орчин, усны эх үүсвэрийг хог хаягдал, хортой зүйлс, малын шавхай бууц, сэг зэмээр бохирдуулахгүй байх, тухай бүр орчиноо цэвэрлэх.

3.6.Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх, нөхөн сэргээх, мод тарихаас бусад зорилгоор бэлчээрийг хашиж хамгаалахгүй байх.

3.7. Бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн зохион байгуулалтад орсон малчид нь Газрын тухай хуулийн 52.2-ыг үндэслэн сумын Засаг даргатай бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж болно.

3.8.Эрчимжсэн суурин мал аж ахуйн эрхлэх зорилгоор хашсан бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.5 -т заасны дагуу тодорхой болзол, гэрээний дагуу ашиглуулж болно.

3.9.Сум, багийн Засаг даргын зөвшөөрөлгүй өвөлжөө-хаваржаа, зуслан-намаржааны бэлчээр, хашаа хороо, худаг уст цэгт өөр аймаг, сумын малыг зөвшөөрөлгүй оруулж, бусдад дамжуулан ашиглуулах, түрээслүүлэх, шилжүүлхийг хориглоно.

3.10. Малчин өрх бүр өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмших эрхийн гэрчилгээ авсан байна.

3.11. Малын оторлолт нүүдлийн үеэр бусдын бэлчээрт дураар мал оруулахгүй байх

3.12.Бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацаа зохицуулалтыг зөрчихгүй байх

3.13. Энэ журмын 2.18-д заасан гадны малчин өрхөд бэлчээр ашиглуулсаны төлбөрийн хэмжээг хонин толгой тутамд хоногт (20₮) төгрөг байхаар тооцож малын хөлийн татвар төлнө. Тэмээнд 5, Адуунд 7, үхэрт 6, ямаанд 2 хонь тус тус оногдохоор тооцоно.

3.14. Өвөлжөө хаваржаандаа гадны мал тавиулаар байлагсан, гадны мал бүхий өрх буулагсан иргэнд энэ журмын 2.18-д заасан хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төлбөр ноогдуулна.

3.14. Малын тоо толгойн албан татварыг сумын ИТХ-ын тогтоосон хэмжээгээр хуулийн хугцаанд нь төлөх.

## **ДӨРӨВ.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг**

4.1.Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж батлах, биелэлтийг хэлэлцэж чиглэл өгөх.

4.2.Энэхүү журмыг үндэслэн сумын "Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам" төслийг хэлэлцэж батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

4.3.Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал аж ахуй, зөгийн аж ахуй зэрэг бэлчээр ашиглагч бусад аж ахуйг хөгжүүлэхдээ бэлчээрийн экологийн чадавхи, тохиромжтой болон хэрэгцээт байдлыг үндэслэн бүсчлэн тогтоох.

## **ТАВ.Багийн иргэдийн Нийтийн Хурлын эрх, үүрэг**

5.1.Жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хуралдаж өмнөх жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх.

5.2.Тухайн жилд хийж гүйцэтгэх бэлчээрийн менежментийн арга хэмжээний санал, шаардагдах зардлыг хэлэлцэж, сумын Засаг даргад уламжлах.

5.3.Бэлчээрийн даацыг тодорхойлох болон бэлчээр ашиглалтын төлөвлөлтөд малчид, малчдын бүлэг, хэсгийн төлөөллийг оролцуулах.

5.4.Бэлчээрийн менежментийн зардлын бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт тавих.

## **ЗУРГАА.Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.**

6.1.Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг тогтоох.

6.2.Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

6.3.Багийн Засаг даргын ажлыг үнэлэхдээ тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө болон энэ журмын хэрэгжилтийг нэг үзүүлэлт болгох.

6.4.Энэ журмын хэрэгжилт, бэлчээр ашиглах гэрээний хүрээнд үлгэр жишээ ажиллаж буй баг, малчдын бүлэг, хэсэг, малчин, мал бүхий өрхийг давуу эрхээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулалд тодорхойлох.

6.5.Гол горхи, булаг шандны эх ундаргыг хамгаалах, эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх, доройтсон бэлчээрийг сайжруулахаас бусдаар бэлчээр хаших тохиолдолд сумын Засаг даргаас зөвшөөрөл авах.

6.6. Малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулах, бэлчээрийг зохистой ашиглах дадлыг бий болгох ажлыг зохион байгуулах.

6.7. Цаг хүндэрсэн тохиолдолд сумын бэлчээрт өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжих, хаваржих малыг оруулахдаа энэ журам болон багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг танилцуулж зөвшилцсөний үндсэн дээр тухайн малчин өрхтэй гэрээ байгуулж, бэлчээр нутгийг зааж өгч нэвтрүүлэх.

6.8. Бэлчээрийн даацыг тодорхойлох, суурь судалгааны тогтоогдсон цэгүүдийг хамгаалах, мониторингийн цэгийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

6.9. Бэлчээрийн менежментийн ажлын хэсгийг байгуулах, ажлын хэсгийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх, нэгдсэн удирдлагаар хангах.

6.10. Сумын төв, суурин газарт мал оруулах, гаргах асуудлыг шийдвэрлэх.

#### **ДОЛОО. Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**

7.1. Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарийг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, санал авах, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

7.2. Тухайн жилд хэрэгжүүлэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, шаардагдах зардлын төсөлд малчин өрх, малчдын бүлэг, хэсгийн саналыг авч тусгах, сумын Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах.

7.4. Багийн иргэдийн Нийтийн Хурлаас гарсан санал, шийдвэр, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, бэлчээр ашиглах хуваарийг малчин өрхүүдэд танилцуулах, хэрэгжилтийг зохион байгуулах.

7.5. Гадны нутаг (отор)-аас (гэрээ, зөвшөөрөл, мал эмнэлгийн үйлчилгээний бичиг)-гүй орж ирсэн малчидтай нэн даруй уулзаж, шаардлага өгч, нүүлгэх, БИНХ-ийн шийдвэргүй нутаг бэлчээр олгохгүй байх

7.5 . “Бэлчээр ашиглалтын журам” зөрчсөн этгээдэд хугацаатай мэдэгдэж хуудас өгч холбогдох арга хэмжээ авах, сумын Засаг даргад нэн даруй мэдэгдэх

7.6 . Бэлчээрийг хуваарийн дагуу чөлөөлөөгүй этгээдийг албадан нүүлгэж, гарсан зардлыг төлүүлэх

7.7 . Малчид болон малчдын бүлэгтэй “Бэлчээр ашиглалтын гэрээ” байгуулах, хэрэгжилтийг хангуулах, хянах, мэдээ мэдээллээр хангах.

## НАЙМ. Маргаан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэх.

8.1. Энэхүү журмыг зохих зөвшөөрөлгүй дур мэдэн зөрчсөн аливаа санаатай болон санаандгүй үйлдэл нь тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

8.2. Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг маргалдагч талууд болон Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга, багийн Засаг дарга, бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн ахлагч нарын төлөөллийг байлцуулан зөвшилцөж, журмын хүрээнд эвлэрлийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

8.3. Маргалдагч талууд эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг даргын хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд хуулийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

8.4. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд шаардлагатай гэж үзвэл бэлчээрт учирсан хохиролыг доорх аргачлалаар тогтооно.

8.4.1. Малын тоог хонин толгойд шилжүүлнэ. Тэмээ-5, Адуу-7, Үхэр-6, Хонь-1, Ямаа-0.9 гэсэн итгэлцүүрээр тооцно.

8.4.2. Нэг хонь хоногт бэлчээрээс 1.6 кг өвс идэхээр тооцож идсэн өвсний нийт жинг бодож гаргана.

8.4.2. Өвсний үнийг орон нутгийн зах зээлийн ханшаар нийт хохиролын хэмжээг тооцож нөхөн төлүүлнэ.

## ЕС. Журам хүчин төгөлдөр болох.

9.1. Энэхүү журмыг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн баталгаажуулсаны дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.

9.2. Энэхүү журамд нэмэлт өөрлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэ тухай саналаа сумын Засаг дарга сумын ИТХ-д өргөн барих ба сумын ИТХ-аар хэлэлцэж шийдвэрлэнэ. Нэмэлт өөрчлөлтийг хуралдааны тогтоолоор баталж энэхүү журмын салашгүй хэсэг байдлаар хавсарган мөрдүүлнэ.

(3.13) Энэ журмын 2.18-д заасан гадны малчин өрхөд бэлчээр ашиглуулсаны төлбөрийн хэмжээг хонин толгой тутамд хоногт (20₮) төгрөг байхаар тооцож малын хөлийн татвар төлнө. Тэмээнд 5, Адуунд 7, үхэрт 6, ямаанд 2 хонь тус тус оногдохоор тооцно.

	Хонин толгойд шилжүүлэх итгэлцүүр	Тоо/ ширхэг	Хонин толгойд шилжсэн дүн	Хоногт 20₮ тооцож хураамж төлхөд	30 хоног бэлчээр ашиглахад төлөх хэмжээ ₮
Тэмээ	5	0	0	0	0
Адуу	7	25	175	3500	105000
Үхэр	6	60	360	7200	216000
Хонь	1	450	450	9000	270000
Ямаа	2	200	400	8000	240000
Нийт		735	1385	27000	831000